

ОЛОН УЛСЫН ИРГЭНИЙ НИСЭХИЙН БАЙГУУЛЛАГЫН АЗИ НОМХОН ДАЛАЙН  
БҮСИЙН ЦАГ УУРЫН ШААРДЛАГУУД – 11 ДҮГЭЭР АЖЛЫН ХЭСЭГ  
ЦАХИМ-ТЕЛЕ УУЛЗАЛТЫН ТАЙЛАН

2022.06.06

Олон Улсын Иргэний Нисэхийн Байгууллагын (ICAO) Ази Номхон Далайн Бүсийн (APAC) Цаг уурын шаардлагууд-ажлын хэсэг 11 (MET/R-WG/11) цахим-теле уулзалтад ахлах синоптик инженер Э.Байгалмаа 2022 оны 5 дугаар сарын 31-аас 6 дугаар сарын 03-ны хооронд цахим хэлбэрээр оролцлоо.

Тус уулзалтад Австрали, Бангладеш, Камбож, Хятад, Хонг Конг Хятад, Фижи, Энэтхэг, Индонез, Япон, Кирибати, Лаос, Малайз, Монгол, Непал, Шинэ Зеланд, Пакистан, Филиппин, БНАСАУ, Сингапур, Шри-Ланка, Тайланд, АНУ, Вануату, Вьетнам зэрэг нийт 24 орон болон Олон Улсын Иргэний Нисэхийн Байгууллага (ICAO), Олон Улсын Агаарын Тээврийн холбоо (IATA)-ны гишүүд зэрэг нийт 145 хүний бүрэлдэхүүнтэй оролцлоо.

Уулзалтад ОУИНБ-ын Ази Номхон далайн Бүсийн Агаарын навигацийн цаг уур, орчны бүсийн ажилтан Петр Дунда туслахаар ажиллаж Австралийн Цаг уурын албаны нисэхийн хэрэглэгчдийн ахлах Ашвин Найду даргалж зохион байгууллаа.

Тус уулзалтаар ажлын удирдамжийн дагуу улс орнуудын шаардлагатай техникийн шинж чанартай, бүс нутагт хамаарах тухайн тусгасан асуудлуудыг ажлын хэсэг хэлэлцэж ОУИНБ-ын тогтоосон Ази Номхон Далайн Бүсийн Агаарын Навигацийн төлөвлөлт, хэрэгжилтийн бүсийн төвийн (APANPIRG) журмын дагуу арга хэмжээ авах, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг хэлэлцэн тохиролцож 10 ажлын хуудас (WPs), 6 мэдээлэх хуудас (IPs) нийт 16 ажлын явц, гүйцэтгэл тавигдсан. Үүнд:

- Нислэгийн хөдөлгөөний менежментийн үйл ажиллагаанд цаг уурын мэдээлэл, үйлчилгээгээр дэмжлэг үзүүлэх бүсийн удирдамжийг шинэчлэх
- Нислэгийн хөдөлгөөний менежмент болон нислэгийн хөдөлгөөний урсгалын менежментийг дэмжих зорилгоор цаг уурын үйлчилгээ үзүүлэх талаар ОУИНБ-ын Ази Номхон Далайн Бүсийн (APAC) судалгааны цаашдын дүн шинжилгээ ба дагаж мөрдөх арга хэмжээ
- Нислэгийн хөдөлгөөний менежментийг дэмждэг өргөн цар хүрээний мэдээллийн менежментэд (SWIM) суурилсан цаг уурын мэдээллийн үйлчилгээнд зориулсан Ази Номхон Далайн (APAC) хэрэглэгчийн шаардлагын талаарх баримт бичгийн төсөл болон түүнд санал оруулах, шинэчлэх
- Бүсийн нислэгийн хөдөлгөөний урсгалын менежмент дэх цаг уурын мэдээлэл

Энэхүү уулзалт нь Ази Номхон Далайн Бүсийн хэмжээний бодлого зохицуулалт, түүний өөрчлөлт, шинэчлэл, цаашид авах арга хэмжээ зэрэг илүү өндөр хэмжээний албан тушаалтнууд оролцох ёстой байсан гэж харлаа.

Тайлан бичсэн:

Ахлах синоптик инженер  Э.Байгалмаа